

Судалгааны төслийн товч хураангуй бэлтгэн илгээх загвар

Мухар олгойн цочмог үрэвслийн үе дэх антибиотик эмчилгээний үр дүнг судлах нь: Олон төвт, санамсаргүй хуваарилалтай, хяналтат, нууцлал- нээлттэй, эмнэл зүйн туршилт судалгаа

Б.Дагва, Ц.Сарнай¹

¹Олон улсын цахим сургалтын төв, Ахисан түвшний сургууль, АШУҮИС

Үндэслэл: Мухар олгойн цочмог үрэвсэл нь дэлхий дахинд түгээмэл тохиолддог мэс заслын яаралтай тусламж шаардлагатай өвчний нэг бөгөөд мэс засал (appendectomy)-аар эмчилж байна. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд мухар олгой нь дархлаа тогтолцоонд төдийгүй хоол боловсруулах замд тодорхой үүрэг гүйцэтгэдэг болохыг судлаачид тогтоосон тул мухар олгойн хүндрэлгүй, цочмог үрэвслийг антибиотик эмчилгээгээр эмчлэх боломжийг эрэлхийлэхээр оролдож байна. Мөн Монгол нөхцөлд хөдөө орон нутагт мэс засал хийх боломж харьцангуй дутагдалтай байдаг тул практик ач холбогдолтой байж болно.

Судалгааны ажлын зорилго: Мухар олгойн хүндрэлгүй, цочмог үрэвслийн үе дэх антибиотик болон мэс заслын эмчилгээний үр дүнг харьцуулан судлах.

Судалгааны арга зүй: Судалгааг олон төвт, санамсаргүй хуваарилалтай, хяналтат, нууцлал- нээлттэй, эмнэл зүйн туршилт судалгааны загвар, тоон судалгааны аргаар хийнэ. Судалгааг 2025 оны 06 сараас 2027 оны 06 сар хүртэл 2 жилийн хугацаанд Улаанбаатар хотын төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд болох Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг, Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг, Улсын Гуравдугаар Төв Эмнэлэгт ирсэн мухар олгойн хүндрэлгүй, цочмог үрэвсэлтэй үйлчлүүлэгчдийг хамруулна. Нийт 216 үйлчлүүлэгч (18-60 насны) оролцох бөгөөд тэдгээрийг санамсаргүйгээр хоёр бүлэгт хуваана: нэг бүлэгт антибиотик эмчилгээ, нөгөө бүлэгт хэвлийн дурангийн мэс засал хийнэ. Эдгэрэлтийн хувь, хүндрэл, сэдрэлийн хувь зэрэг үзүүлэлтийг харьцуулна. Мэдээллийг SPSS программын тусламжтайгаар Т-тест, ANOVA, хи-квадрат тестүүдээр тооцоолж, статистикийн ач холбогдлыг Р утга тооцож үнэлнэ.

Хүлээгдэж буй үр дүн: Мухар олгойн хүндрэлгүй, цочмог үрэвслийн үе дэх антибиотик болон мэс заслын эмчилгээний үр дүн харьцуулан тодорхойлогдоно. Мөн антибиотик эмчилгээ хийлгэсэн үйлчлүүлэгчдийн 1 жилийн хугацааны дараах сэдрэл болон хүндрэлийн хувь тодорхойлогдоно.

Түлхүүр үг: Мухар олгойн үрэвсэл, Антибиотик, Мухар олгойн мэс засал эмчилгээ, Эмнэл зүйн туршилт судалгаа, Эмчилгээний үр дүн.